

	үнэлгээний хуудсыг боловсруулан Глобаль Санд илгээх саналыг гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталсаныг Глобаль Санд хүргүүлсэн.		Г 5-Р САРЫН 8-НЫ ӨДӨР ГЛОБАЛЬ САНГААС ШИЛЖҮҮЛСЭН. ДОТООДОО САНХҮҮЖИЛТ ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛ ЯВЦЫГ ХАРААХАН ШИЙДЭГҮЙ БАЙНА.
хөтөлбөр#8	Дараагийн удаагийн хурал дээр ХЗН-ээс ямар нэг зүйл танилцуулахаар хурлын хөтөлбөрт оруулсан бол заавал урьдчилан бэлтгэсэн материалыг ҮЗЗ-ийн гишүүдэд тараах шаардлагатай гэдгийг дахин сануулах байна. Хурлын цаг давчуу байхад гишүүд зохих материалтай танилцаад явах нь илүү хүртээмжтэй байна шүү дээ. Энэ асуудал урд нь ч бас гарч байсан тул ХЗН-ийн зохицуулагч энэ асуудлыг анхааралдаа авч ажиллана гэж найдаж байна.	ХЗН, зохицуул агч	80%

Ази дахь ХДХВ-д өндөр эрсдэлт бүлгийн хүн амын ХДХВ-ийн тусламж үйлчилгээний тогтвортой байдлыг хангах хөтөлбөрийн талаар Д.Мягмардорж, ЗЭМ ТББ мэдээлэл хийлээ. /Хавсралт №1/

Д.Мягмардорж, ЗЭМ-ын гүйцэтгэх захирал: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэхүү Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ/ДОХ-ын 8 орны хамтарсан төслийг МУ 2019-2021 онд хэрэгжүүлэхээр болсон. Энэ талаар товчхон мэдээлэл өгье.

Төслийн зорилго:

- 2030 он гэхэд ХДХВ-ийн халдвар дамжих болон ДОХ-ын улмаас нас баралтыг зогсоож, зорилтот хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний тогтвортой байдлыг бий болгоход чиглэж байна.
- ҮХА-аар та бүхний мэдэж байгаачлан АFAО сонгогдсон. Энэ байгууллага маань 8 орны төслийг нэгтгэн Глобаль Санд өргөн барьж улмаар 2019 оны 6 сарын 15-нд ГС-аас баталгаажуулан гарын үсэг зурсан. Түүнээс хойш тус 8 оронтой эхнээсээ гэрээ хийгдэж эхэлж байгаа бөгөөд тус үйл ажиллагаа зэрэг хийгдэхгүй байна.
- Монгол улсын хувьд АFAО-тай “Залуус эрүүл мэнд төв” ТББ харилцан гэрээгээр ажиллахаар сонгогдсон.

Миний өгөх гол мэдээлэл бол ГС-ийн төсөл болон бүсийн төсөл дээр ҮЗЗ-ийн бүтэц ямар байх тал дээр нилээд ач холбогдол өгч байсан. Тиймээс энд ҮЗЗ-ийн оролцоо маш чухал болохыг сануулах нь зүйтэй болов уу. Ерөнхий бүтцийг танилцуулбал ГС-аас санхүүжилт АFAО-д орж тэрхүү санхүүжилтыг хянах зорилгоор Бүсийн Удирдах зөвлөл /НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрөөр удирдуулсан/ гэх бүтэц байна. Мөн Улс орон бүрт ҮЗЗ байх ба түүнээс арай жижиг бүэц бүхий Үндэсний зөвлөх хороо ажиллана. Тиймээс тус Үндэсний зөвлөх хороог ҮЗЗ дотроо байгуулах эсвэл тусдаа өөр бүтэц байгуулах эсэх талаар бүсээс мэдээлэл авах шаардлагатай байгаа. Энэ тал дээр ҮЗЗ нилээд идэвхитэй оролцох бололцоотой байх болов уу гэж харж байна.

Залуус эрүүл мэнд төв ТББ нь тодорхой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд бусад байгууллагуудтай гэрээлэн гүйцэтгүүлж болно. Залуус эрүүл мэнд төв нь улс орны түвшинд түншлэлийг дэмжиж, гол түншүүдтэй (ЭМЯ, ҮЗЗ, Глобаль сангийн үндэсний хөтөлбөр, НҮБ-ын агентлагууд гэх мэт) мэдээлэл солилцох боломжийг олгох бөгөөд үйл ажиллагаандаа техникийн болон удирдамжийн зөвлөмжийг ашиглан АFAО, Бүс нутгийн зөвлөх хороо, Улс орны зөвлөх хороотой хамтран ажиллана.

• **Бүсийн зөвлөх бүлгийн үүрэг**

НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрөөр удирдуулсан бүсийн зөвлөх хороо ажиллах бөгөөд энэхүү бүтцийн гишүүдэд бүсийн байгууллагууд болон зорилтот хүн амын бүлэг, сүлжээ, техникийн түншүүд болон бусад байгууллагуудад багтана.

- Үндсэн хүлээн авагчийн үйл ажиллагаанд өндөр түвшний оролцоогоор хангах.
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийхэд зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх:
- Хөтөлбөрийн зорилго, хэрэгжилтэнд анхаарал хандуулах, хамтын ажиллагаа уялдаа холбоог бий болгох.
- Хөтөлбөрийн боловсруулалт, шинэчлэлт, тогтвортой байдлыг хангах тал дээр зөвлөмж өгөх.

• **Улс орны зөвлөх хорооны үүрэг**

- Хөтөлбөр хэрэгжүүлэх явцад зорилтот хүн ам болон хамтран ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд, засгийн газар болон бусад түншүүдийн хамтын ажиллагааг дэмжих.

- Орон нутгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зөвлөн дэмжих, бүс нутгийн түншүүдээс үзүүлэх дэмжлэгийн талаар зөвлөмж өгөх.
- Төлөвлөгдсөн үйл ажиллагаануудын уялдаа холбоог дэмжих.

Нэмэлт мэдээлэл:

- Бүсийн зөвлөх хорооны уулзалт 5 сарын сүүлээр болсон ба ҮЗЗ-ийн гишүүн Б.Сувд оролцсон. Тиймээс та бүхэн энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг түүнээс авах болмжтой.
- 6-р сарын 20 гэхэд санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурах мэдээ ирүүлэх байсан боловч одоогоор мэдээлэл ирээгүй байна.

Та бүхэндээ баярлалаа!

Хөтөлбөр #2 Глобаль Сангийн дэмжлэгтэй хэрэгжиж буй төслүүдийн хөдөө орон нутаг дахь хэрэгжилтийн байдлыг танилцуулах

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Т.Энхзаяа, ҮЗЗ-ийн гишүүн, ЭМЯ-ны НЭМГ дарга: Дараах танилцуулгыг хийлээ. /Хавсралт №2/

16 зөөврийн дижитал рентген аппарат - 12 аймаг, 2 дүүрэг, ХӨСҮТ, хорих 429-р анги

	Аймаг / дүүрэг	Санхүүжүүлэгч	Нийлүүлсэн он	Нийт -16
1	Дорнод	ГС	2017	6
2	Ховд	ГС	2017	
3	Сэлэнгэ	ГС	2017	
4	Баянзүрх дүүрэг	ГС	2017	
5	Хорих 429-р анги	ГС	2017	
6	Чингэлтэй дүүрэг	Дүүргийн ЗДТГ	2017	
7	ХӨСҮТ СТА	ГС	2018	10
8	Дархан-Уул	ГС	2018	
9	Дорноговь	ГС	2018	
10	Хөвсгөл	ГС	2018	
11	Завхан	ГС	2018	
12	Төв	ГС	2018	
13	Баянхонгор	ГС	2018	
14	Өвөрхангай	ГС	2018	
15	Хэнтий	ГС	2018	
16	Увс	ГС	2018	

Илрүүлэг шинжилгээний дүн, аймгаар, 2018 оны жилийн эцэст

№	Аймаг дүүрэг	Рентген шинжилгээ	Цэрний шинжилгээ	Нян батлагдсан	судлалааг
1	Баянхонгор	0	0	0	
2	Дархан-Уул	1059	56	2	
3	Дорноговь	1686	95	3	
4	Завхан	200	39	3	
5	Өвөрхангай	2189	145	2	

6	Төв	3558	75	0	0
7	Увс	0	0	0	0
8	Хөвсгөл	0	0	0	0
9	Хэнтий	887	23	3	10
10	ХӨСҮТ	1311	86	3	0
		10890	519	16	13

Илрүүлэг шинжилгээнд хамруулсан хүний тоо нэмэгдсэн

- МХЕГ “Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах тухай” Улсын байцаагчийн зөвлөмжийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог зохион байгуулж байгаа эмнэлгийн байгууллагуудад хүргүүлсэн. /2019-5-29/
- 2018, 2019 оны эхний 5 сард нийт 53 сургууль, 1 цэцэрлэгийн нийт 4,675 хүүхдэд туберкулины сорил, 7,556 багш ажилтан, сурагчдад цээжний рентген шинжилгээ хийж, 67 сүрьеэтэй тохиолдлыг эрт илрүүлж, эмчилгээнд хамруулсан.

Цаашид авах арга хэмжээ

- Хяналт үнэлгээний зөвлөмжийг дахин хянах
- Мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран хяналтыг зохион байгуулах
- Та бүхний харж байгаачлан Увс, Завхан аймгуудад хэрэгжилт хангалтгүй байна. Манай мэргэжилтэн саяхан томилогдсон тул яг энэ асуудлын араас яваад байсангүй. Одоо эдгээр асуудлуудыг шийдвэрлэх боломжтой болж байна. Цаашид тус аймгуудад зөвлөмжийг хүргүүлнэ гэж төлөвлөж байна.

Сүрьеэгийн чиглэлээр цаг үеийн мэдээлэл хийх

Энэ асуудлын хүрээнд ЕБС-иудад хийгдэж байгаа сүрьеэгийн оношлогоо эмчилгээний талаар танилцуулья. Энэ жилээс эхлэн ГС-ийн санхүүжилтээр ЕБС-иудийн сүрьеэгийн эрт илрүүлэг, үзлэгийг зохион байгуулах шийдвэр гарган эрчимтэй ажиллаж байна. Түүнчлэн ЭМС-ын 2017 оны А306-р тушаалын зааврын дагуу 2018-2020 онд Нийслэлийн ЕБС-иудийн сүрьеэгийн эрт илрүүлэг, үзлэгийг жил бүр зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд

- 2018 онд 23 сургууль дээр 4,160 багш, сурагчдыг хамруулан 19 сүрьеэгийн тохиолдлыг олж илрүүлэн эмчилгээнд хамруулсан.
- 2019 оны 5 сарын 16-ны байдлаар нийт 25 сургууль, 1 цэцэрлэгийн нийт 6,932 үүнээс 3,895 хүүхэд, 3,037 багш ажилчдыг хамруулсан сүрьеэгийн үзлэг оношлогоо хийж нийт 47 сүрьеэ олж илрүүлэн эмчилгээнд хамруулж байна.

Одоо та бүхэндээ зарим Улсын сургуулиудад хийгдэж байгаа үзлэгийн талаарх нарийвчилсан мэдээг танилцуулья. Үүнд:

Нийслэлийн ХУД-ын 15-р сургууль 1974 онд 920 хүүхдийн багтаамжтайгаар байгуулагдсан. Одоогоор нийт 1737 сурагч, 111 багш ажилчидтай байна. 2013 оны 9 сараас 32-р сургуулийн 310 сурагч, 23 багш ажилчид нэмэлтээр ирж сүүлийн жилүүдэд 2-3 ээлжээр хичээллэн нягтрал нь ихэссэн байна. 2017 оноос тус сургуульд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

- Сүүлийн 3 жилд 4 удаа сүрьеэгийн үзлэг шинжилгээ зохион байгуулж давхардсан тоогоор 5000 гаруй багш, сурагчдыг хамруулсан. 2019 онд Сүрьеэгийн үзлэг, шинжилгээ оношлогоонд нийт багш ажилчдын 95%-ийг хамруулж, сүрьеэгээр өвчилсөн 39 тохиолдлыг илрүүлэн яг одоогоор 20 хүүхдийг эмчилгээнд хамруулж байна. Мөн Сүрьеэгийн далд халдвартай 519 хүүхдийг илрүүлж, 114 хүүхдийг сүрьеэгийн урдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулсан. Одоо 208 хүүхдийг хамруулж байна.

Төв аймгийн Сүмбэр сумын 1-12-р ангийн нийт 288 сурагчид, 37 багш, ажилчидтай сургууль дээр 3 дугаар сарын 25-нд анхны сүрьеэгийн тохиолдлыг илрүүлсэн. 5Б ангийн багш өвчтэй байснаар уг илрүүлэг, оношлогоог хийх болсон. Уг оношлогоог хийснээс хойш 2 сурагч сүрьеэ өвчинтэй гарсан. Тус сумаас нийт 32 хүн сүрьеэгийн халдвартай гарсан. Түүнчлэн 162 сурагч урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдаад явж байна.

“Тэмбүүг устгая” үйл ажиллагааны талаарх товч танилцуулга

Нийт БЗДХ-ын 38%-тэмбүү, 25%-трихимониаз, 29%-заг хүйтэн, ХДХВ-0,2% байна. 15-23 насны хүн

амын дунд өвчлөл маш өндөр байна. Энэ төрлийн өвчний гол асуудал нь хүн амын шилжилт хөдөлгөөн, архи хэтрүүлэн хэрэглэх, эрт бэлгийн харьцаанд орох, бэлгийн олон хавьтагчтай байх, биеэ үнэлэлт зэрэг эрсдэлт зан үйл газар авч байгаатай холбоотогоор 1990 оноос хойш БЗДХ эрс нэмэгдсэн байна.

Тэмбүү өвчний хувьд эрсдэлт бүлэг, жирэмсэн эмэгтэйчүүд, нийт хүн амын бүх бүлэгт өвчлөлийн тохиолдлууд өссөөр байна. 2018 онд нийт 6,580 тэмбүүгийн тохиолдол бүртгэгдсэний 65% нь эмэгтэйчүүд, 34 %-ийг нь эрчүүд эзэлж байна. Энд яагаад эмэгтэйчүүд илүү байна гэхээр та бүхний мэдэж байгаачлан жирэмсний илрүүлэг үзлэгийг жирэмсний явцад 2 удаа хийдэг тул илрүүлэг нь их байгаа юм.

Төрөлхийн тэмбүү 2015 онд 52, 2016 онд 42, 2017 онд 46 гэх мэтээр өндөр тоогоор гарч байгаатай холбогдуулан Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Тэмбүү өвчнийг устгах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Их дээд сургуулиудын оюутнууд, гар аргаар алт олборлогчид, уул уурхайн салбарт ажиллагсад, алсын тээврийн жолооч, орон гэргүй эмзэг бүлгийн хүмүүсийг БЗДХ-ын үзлэг, шинжилгээнд хамруулахаар ХЗЯ, БСШУЯ, ЗТЯ, Уул уурхайн яам болон Засаг дарга нартай энэ үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд нилээд их санхүүжилт шаардлагатай байгаа.

/БЗДХ, тэмбүүгийн талаарх 2 шторкыг нийт гишүүдэд үзүүлж танилцуулав./-Хүмүүс мэдээ үзэж байх хугацаанд нь ард иргэдэд хүргэх зорилго бүхий маш богино хугацаатай мэдээлэл хүргэх шторк юм.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ТББ	<p>Г.Нямцүрэв: Өнгөрөгч 2018 онд 6,580 тэмбүү бүртгэгдсэн гэсэн байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Эмчилгээний үр дүн хэдэн хувьтай гарсан байсан бэ? Илэрсэн халдваруудаа 100% эмчилж чадаж байна уу? 2. Халдварт өвчний талаар статистик мэдээлэл улирал тутам гарч байхад алдаа дутагдал гарч байсан уу? Жишээлбэл ханиадны улиралд БЗДХ бага харагдаад бусад үед их харагдаад байх юм. Бусад төрлийн өвчинтэй холбох, холих хэрэг байна уу? Энэ талаар бусад орны туршлага юу байна вэ? Энэ талаар ЭМЯ ямар бодлого баримталж байгаа вэ? 3. “Улаан тарианы 2-р аян” гээд байх юм. Энэ нэршлийн хувьд зөв үү? Жишээлбэл тэр тариа 1980-аад оны сүүлээр байхгүй болсон гэж байхад одоо тарьж байгаа тарианы нэрээр нь цагаан гэж нэрлэх үү? Энэ талаар мэдээлэл өгнө үү.
ЭМЯ-УХА	<p>Т.Энхзаяа: Өөрийн хэмжээнд эдгээр асуултууд хариулья.</p> <ol style="list-style-type: none"> 1. 6580 гэж нийт хүн амд илрүүлэг үзлэгт хамруулсан тоог хэлж байна. МУ-д жил бүр дунджаар 4000 сүрьеэгийн батлагдсан тохиолдол илрүүлж байна. Энэ тохиолдлуудын ард нилээд олон халдвартай хүмүүс байгаа. Ер нь бол ЭМЯ-аас бүртгэгдсэн хүмүүсээс илүү тархалтын судалгаагаар илэрсэн хүмүүсийг илрүүлж эмчлэх гол зорилготой байгаа. 2. БЗДХ ханиад томууны улиралд багасаад байгаа талаар нарийн хэлж мэдэхгүй байна. Яг өөрийн тань хэлсэнээр харья гэж бодож байна. Ер нь БЗДХ зуны улиралд ихэсдэг нь хүмүүсийн зан үйл, шилжилт хөдөлгөөн ихэсдэг эсвэл бусад өөр хүчин зүйлтэй холбоотойгоор ихэсдэг байж болох талаар манай судлаачид нарийн тайлбарлах боломжтой байдаг байх. Бусад оронд БЗДХ зун, өвлийн аль улиралд ихэсдэг талаар мэдээллийг яг одоо өгөх боломжгүй байна. 3. Ер нь ЭМЯ-аас төлөвлөж буй үйл ажиллагааг “Улаан тарианы аян” гэж нэрлэхгүй. Энэ нэгхэн удаа зохион байгуулаад дуусах аян хэлбэрээр явагдахгүй. Өнөөдрийг хүртэлх үйл ажиллагааг эрчимжүүлэх явдал юм. Нөгөө талаар бид хамгийн эхний мэдээлэлдээ “Улаан тариа” гэж хэлсэн нь тухайн үед нийт ард иргэдийн анхаарлыг татах зорилготой байсан. Одоо бол энэ арга үүргээ гүйцэтгэн хүмүүс анхааралдаа авсан гэж бодож байна. Тиймээс бид “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр-Тэмбүүг устгая” гэдэг нэрийн дор тус үйл ажиллагааг хийх болно.
ТБ	<p>Б.Хонгорзул: 1. ГС-ийн төслийн шугамаар зөөврийн дижитал рентген аппаратаар хангасан гэж мэдээлэл өглөө. Нийслэлийн аль дүүргүүдэд зөөврийн дижитал рентген аппарат өгсөн бэ?</p> <p>2. Нийслэлийн дүүргүүдийг хамарсан үзлэг оношлогоог хийх гэж байгаатай холбоотой ГС-ийн арга хэмжээтэй уялдуулж, түүний хүрээнд зохицуулагдаж байгаа төлөвлөсөн зүйл байгаа юу?</p>
ЭМЯ-УХА	<p>Т.Энхзаяа: 1. ГС-аас зөөврийн дижитал рентген аппаратыг ХӨСҮТ-ийн тандалт судалгааны алба хүлээн авсан бөгөөд бусад нийслэлийн дүүргүүдэд байхгүй. Суурин аппарат ч дутагдалтай байна.</p> <p>2. Одоо хийгдэж байгаа төлөвлөгөөг эрчимжүүлэх үйл ажиллагаа, ГС-ийн хийх гэж байсан үйл ажиллагааны төлөвлөгөөг харьцуулан үзээд, хооронд нь холбох ажиллагааг хийж өгч байна. Үүнд хаана тоног төхөөрөмжөөр хангасан эсэх, хаана оношлуурын тоног төхөөрөмж хүргэгдсэн байгааг болон хөтөлбөрийг гарааны байдлаар яаж эхлэх талаар төвлөрсөн арга хэмжээ авахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p>

ТББ	<p>Б.Сувд: 1. ҮЗЗ-ийн зөвлөмжийг хүлээн авч бодлого шийдвэртээ тусгасан зүйл байдаг уу?</p> <p>2. Ядуурал, ажилгүйдэл болон бусад төрөлхийн тэмбүүгийн учир шалтгааныг оновчтой олж тогтоон түүнд чиглэсэн ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй. Учир нь жирэмсний хяналтанд байгаа хүнээс энэ асуудал гараад байгаа нь аюултай санагдаж байна.</p> <p>3. Хувийн болон өрхийн эмнэлгүүд дээр түргэвчилсэн тестийг ашиглаад байна. Тэдгээр газруудад эерэг гарахад бөөн маргаан үүсээд байна. Тэд өөрсдөө түргэвчилсэн тестийг эм ханган нийлүүлэх байгууллагаас захиалан авч байна. Тэр нь монгол орчуулгатай ирсэн байх боловч орчуулгын зөрүү байгаад байна. Жишээ нь: Англиар 15 минут гэснийг, монголоор 20 минут гэх мэтээр бичсэн байх юм. Үүнийг анхаарах боломж байна уу? Яг тэр онцлог жишээнүүдээс үүдэн төрөлхийн тэмбүү гарсан байвал яана даа. Тэгэхээр нөгөө том асуудлыг бус жижиг асуудлаасаа эхлээд хумиж явбал яасан юм бэ?</p>
ЭМЯ-УХА	<p>Т.Энхзаяа: 1. ҮЗЗ-ийн 80 дахь хурлаас би хуралд оролцож эхэлсэн. Тэр цагаас ҮЗЗ-ийн хурлын зөвлөмжид орсон асуудлуудын хэрэгжилтийг хангахаар ажиллаад явж байна. Улмаар бүх асуудлуудыг дараа дараагийнхаа үйл ажиллагаанд тусгаад явна. ҮЗЗ-ийн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөндөө оруулаад явна. Тиймээс та бүхний ярилцан зөвшилцөж буй эдгээр асуудлууд бидний үйл ажиллагаанд санал санаачлага болох ач холбогдолтой гэдгийг хэлэх байна.</p> <p>2. Ядуурлын асуудал байгаа тиймээс “Тэмбүүг устгая” үйл ажиллагааны хүрээнд нилээдгүй ажлыг төлөвлөж байна. Тэгэхээр ЭХЭМҮТ, НЭМГ, өрхийн эмнэлгүүд, бүх амаржих газруудтай хамтран жирэмсний хяналт дээр юунд анхааран ажиллах ёстой болон хэрхэн эмчилж эдгэрүүлэх талаар нэгдсэн зөвшилцөлд хүрэн үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллах болно.</p> <p>3. ЭМЯ-аас 2018 онд оношлуурын чанарын асуудал дээр үнэлгээ хийсэнтэй холбоотой маш олон зөвлөмж гарсан. Үүнд суурилан түргэвчилсэн оношлуурын худалдан авалтыг нийтлэг нэгдсэн журмаар хийх зарчим барьж байна. Дараа жилээс нэгдсэн худалдан авалт хийхээр төлөвлөсөн тул одоогоор бүх аймаг, дүүргүүдэд зөвлөмж хүргүүлсэн.</p>
ОУБ	<p>А.Цэцэгмаа: Оношлогооны тестийн чанарыг сайжруулах тал дээр арга хэмжээ авч байгаа гэж ойлголоо. Мөн оношлогоо хийж буй хүний ур чадварт анхаарах хэрэгтэй. Баянхонгор аймгийн эмч 1-р улиралд тэмбүүгийн илрүүлэлт 2018 оны нийт илрүүлэгтэй ижил түвшинд гараад буйг эмнэлэгийнхээ удирдлагад хэлэхэд тус эмнэлгээс хариу арга хэмжээ авч өгөхгүй байсан. Ингээд хамт явж байсан ХӨСҮТ-ийн туршлагатай эмч нар үзэхэд нийт оношлогооны 50% буруу гарсан байсан. Улмаар энэ асуудлыг тодруулахад, давхар тест ирээгүй гэх мэт маш олон асуудал тоочоод байсан. Гэтэд цаана нь хүний амьдралын маш том асуудлыг хөндөөд байх жишээтэй. Тиймээс эмчийг сургах, чадавхижуулах асуудал учир дутагдалтай санагдсан. ХӨСҮТ-ээс тэр дор нь сургаад явсан боловч цаашид анхаарах хэрэгтэй гэж бодож байна.</p>
ЭМЯ-УХА	<p>Т.Энхзаяа: Үйл ажиллагааны чанар хүртээмжийг эрчимжүүлэх ажлын хүрээнд 7 бүсчилсэн зөвлөгөөг цахим хэлбэрээр хийхээр төлөвлөн ажиллаж байгаа.</p>
ТБ	<p>Ж.Мөнхжаргал: 1. Бид өмнөх хурлаар оношлогоо, зургийн чанар, хүний нөөцийн чадавхийн тал дээр арга хэмжээ авч ҮЗЗ-д танилцуулах үүрэг өгсөн. Түүн дээр нэмэлт мэдээлэл байгаа юу?</p> <p>2. Цэрэг татлагын үзлэгээр сүрьеэ болон БЗДХ-ыг илрүүлэх шинжилгээ ямар түвшинд хийгдэж байна вэ?</p> <p>3. ДОХ-ын Үндэсний Зөвлөлийг хэзээ хуралдуулах вэ?</p> <p>4. Орон нутагт тогтоосон лабораторийн гадаад, дотоод босго хувь маш бага байна. Тиймээс 400 оношлогооны 10-г УБ-руу явуулж баталгаажуулан энэ босгыг өсгөх ямар боломж байна вэ?</p>
ЭМЯ-УХА	<p>Т.Энхзаяа:</p> <p>1. Хүний нөөцийн сургалтанд та бүхэнд нилээн хэдэн тайланг танилцуулах боломжтой.</p> <p>2. Цэрэг татлагын асуудал дээр надад ямар нэг мэдээлэл алга байна.</p> <p>3. ДОХ-ын Үндэсний Зөвлөлийн хурлыг ч бас мэргэжилтэнтэйгээ холбогдон ярилцах хэрэгтэй байна.</p> <p>4. ЭМЯ асуудал хариуцсан мэргэжилтэнгүй хагас жил боллоо. Өнөөдрийн байдлаар мэргэжилтэн томилогдсон. Тиймээс өнгөрсөн хугацаанд би яг өөрөө гал унтрааж ажиллаж байсан. Сүрьеэ болон тэмбүүгийн асуудал хүндээр тавигдаж байсан. Тиймээс оношлогооны чанарын асуудалд өнөөдөр ямар нэг тайлбар өгч чадахгүй байна. Гэхдээ цаашид хариуцсан мэргэжилтэнтэй болж байгаатай холбоотойгоор эдгээр асуудлууд дээр ахиц гарна гэж бодож байна.</p>
ТБ	<p>Ж.Мөнхжаргал: 1. Цэрэг татлагын үзлэгээр орохоор өөрсдөө ирж байгаа залуусыг шинжлэхэд анхаарч ажиллана уу.</p> <p>2. Лабораторийн гадаад, дотоод хувийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Мөнгөтэй хувийн хэвшил энэ талаар үйл ажиллагааны нилээд хувийг авч яваад байна шүү. Нэгдсэн эмнэлэг бүрт байрладаг лабораториудыг хараарай. ЭМЯ эзгүй мэт л яваад байна.</p>

	<p>3. Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн цаана байгаа эрэгтэйчүүдийг оношлох, эмчлэх хэрэгтэй. ЭМД-аар эмийг нь хангахгүй бол болохгүй нь ээ.</p> <p>4. Аймаг бүрт байгаа агааржуулалтын асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Бидний очсон 10 аймгийн 7-д нь энэ асуудал үүсээд байна.</p>
АШУУ ИС	<p>Р.Оюунгэрэл: БЗДХ тэр дундаа тэмбүүгийн илрүүлэлт жирэмсний хяналтаас илрээд байна гэж ажиглаад байна. Тэгэхээр тэмбүүтэй гэж оношлогдсон хүмүүсийн хэдэн хувь жирэмсний хяналт, урьдчилан сэргийлэх үзлэг, хувиараа ирж үйлчлүүлж байгаа вэ? гэдэгт ялгавартайгаар ажлаа хянан үзэх хэрэгтэй. Тэмбүү, БЗДХ-ийн үед хувийн эмнэлгүүдэд ялангуяа эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгээр үйлчлүүлсэн хүмүүсийн хувьд ямар байгаа нь тодорхойгүй байна. Учир нь хувийн эмнэлгүүд хувь хүний мэдээллийг цааш өгдөггүй байна. Тиймээс хувийн эмнэлгийг хяналттай болгох хэрэгтэй гэж үзэж байна. Тиймээс ЭМЯ энэ талаар бодлогын арга хэмжээ авах хэрэгтэй.</p> <p>Бид бүсчилэн 5 лаборантыг аймгуудаас авчраад сургаад явуулж байсан. Гэтэл тэд чадавхижадаггүй буцдаг. Тиймээс сургалтыг ажлын байран дээр нь үргэлжилсэн хугацаагаар сайн мэргэжилтэнгээр хийлгүүлэх цаг нь болсон байна. Үүнийг ЭМЯ-аас их дээд сургуулиудтай хавсран хийж төсвөө гаргах хэрэгтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.</p>

Зөвлөмж:

Б.Мягмар: Дүгнэн хэлэхэд Т.Энхзаяа дарга ажил ихтэй байсан болоод тэр үү, тоног төхөөрөмжийн ашиглалт болон сүрьеэ, тэмбүүгийн талаар ЭМЯ-аас авч хэрэгжүүлж буй салбарын асуудлыг яриад явчихлаа. Цаашид яг хэлэлцэх асуудалд орсон сэдвийн дагуу цагтаа багтаан ярих хэрэгтэй. Мөн дараагийн хурал дээр ХЗН, ХӨСҮТ-ийн төлөөллүүдийг байлцуулан гишүүдийн асуултанд хариулах байдлаар хуралд оролцох хэрэгтэй тул анхаарах хэрэгтэй гэсэн зөвлөмжийг өгье.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		
		Эсрэг>		
		Санал өгөхөөс түдгэлзэх		

Хөтөлбөр #3	<p>ҮЗЗ-ийн хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцсан ажлын тайлан:</p> <ul style="list-style-type: none"> • Шинэ өөдрөг амьдрал ТББ, Төгс бүсгүйчүүд ТББ, Налайх дүүрэг • Төв, Дундговь, Өмнөговь аймгууд • Баянхонгор, Өвөрхангай аймгууд <p><i>Асуулт хариулт</i></p>
--------------------	--

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Улаанбаатар хотын хяналтын ажлын тайлан

- Шинэ өөдрөг амьдрал ТББ, Төгс бүсгүйчүүд ТББ, Налайх дүүрэгт танилцсан айлчлалын танилцуулгыг С.Дондов, ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүн танилцууллаа;/Танилцуулгыг Хавсралт №3-аар оруулав/

Та бүхэнд дэлгэрэнгүй тайлан болон танилцуулгыг тараасан учраас аль болох нэгтгэн хэлье.

**Налайх дүүргийн Эрүүл Мэндийн Төв
БЗДХ-ын кабинет, СДЗШ-ний төв**

Нөхцөл байдал

- БЗДХ-ын кабинетийн хувьд 1 эмч, 1 нийгмийн ажилтан, 2 сувилагчтай. Эрт илрүүлгийн үйл ажиллагааг сайтар зохион байгуулдаг. Төрийн болон ТББ-уудтай нягт хамтран ажилладаг.

Тухайлбал АШУҮИС, НЭМГ, МУЗН зэрэг байгууллагуудтай хамтран 2 удаа үзлэгийн арга хэмжээ зохион байгуулсан. Түүнчлэн Good Neighbours төслийн хүрээнд 1 удаа эрт илрүүлэг, үзлэгийг зохион байгуулсан. Эрсдэлт бүлэг байх газрууд болон байгууллагуудаар бүтэн тойрч шинжилгээ хийдэг. ЦГ, уурхайд, аялал жуулчлалын газрууд, буудлуудаар шалгалт хийн ажилладаг.

- Тэрэлжээс 1 ХДХВ-тэй өвчтөн илэрсэн. ХДХВ-тэй 1 хүнийг зөвлөгөөнөөр групп оруулсан.

Тулгамдаж буй асуудал

- Эмч мэргэжилтэн хангалтгүй, дутагдалтай.
- Гадаад хүмүүсээс илүү монгол хүмүүсд өвчлөл ихээр илэрдэг.

Нэгдсэн Эмнэлгийн Сүрьеэгийн диспансер

Нөхцөл байдал

- Сүрьеэгийн диспансерийн агааржуулалтын системийг ГС-ийн 35,000 ам.долларын санхүүжилтээр байршуулсан.
- Тайланг сар бүр TUBIS програм дээр шивж хүргүүлдэг. Налайхын дүн бүртгэгч өөрийн кодоор нэвтрэн ордог тул хувь хүний нууцлал хангагдсан. Эмнэлэгт 2018 оны байдлаар 54 өвчтөн 84 хонож эдгэрээд гарсан. Өвчлөлд өртсөн хүмүүс амьдралын түвшин тааруу байдаг тул эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх дуртай байдаг. Түүнчлэн өвчтөнгүүдийн хоолны илчлэгийг ихэсгэн, тав тухыг нь бодолцон шинээр орох эмнэлгийн өрөөнүүддээ зурагт тавихаар төлөвлөсөн.
- Халдварын сэжигтэй хүмүүсийг ялган оношлоод илрүүлэхийг эрмэлзэн ажилладаг. Эрүүл хүмүүсийг үзлэг, шинжилгээнд хамруулахдаа тусдаа өрөөнд оруулж үйлчилдэг.

Саад бэрхшээл

- Эмч мэргэжилтэн хангалтгүй, дутагдалтай.
- Оношлогооны тоног төхөөрөмж байхгүй тул ХӨСҮТ-рүү сорьцыг илгээдэг нь цаг алдахад хүргэдэг.
- Оношлогоо хийх үүднээс Нийслэлээс зөөврийн рентген аппаратыг түр хугацаанд авч хэрэглэдэг нь Налайх дүүрэг шиг онцлог нөхцөл байдалтай уул уурхай ихээхэн хөгжсөн газарт цагаа олоогүй хуваарилагдан ирэх үед үр дүн муу гарах магадлалтай.
- Алс хол, зайдуу байгаа өвчтөнгүүдэд хүрч ажиллахад хүндрэлтэй байдаг.
- Гэр оронгүй тэнэмэл хүмүүсийг эмчилгээнд хамруулахад асуудал тулгардаг.
- Эмч нар олон төрлийн ажил зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг, туслалцаа хэрэгтэй болдог.
- Сүрьеэгийн өвчлөлд өртсөн хүмүүст туслалцаа үзүүлэх зорилгоор хандивын хайрцаг нээсэн байна. Тус хандиваар Сүрьеэ өвчтэй хүмүүст эм, витамин авч өгдөг. Зарим тохиолдолд эмзэг бүлгийн өвчтөнгүүдэд зориулан хэрэгцээтэй зүйлсийг нь авч өгдөг байна.

ҮЗЗ-ийн Зөвлөмж

- ГС-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй үйл ажиллагааны санхүүжилтыг өөрийн байгууллагын төсөвтөө жил бүр бага багаар тусган ажиллаж цаашдын тогтвортой байдлыг хангах.
- Түүнчлэн санхүүжилтыг нэмэгдүүлэхийн тулд өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан олон улсын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдан ажиллах хэрэгтэйг санууллаа. Жишээлбэл: Канад Сангийн тэтгэмжээр ХӨСҮТ-ийн 3 өрөөг бүрэн тохижуулсан. Энэ мэт туршлагыг судлан санхүүжилтыг босгох бололцоотой.

“Төгс Бүсгүйчүүд” ТББ

Ололт амжилт

- Хөтөлбөр хэрэгжиж буй хугацаанд эмэгтэй биеэ үнэлэгчдийн дунд ХДХВ-ийн халдварын тохиолдол бүртгэгдээгүй. ЭБҮ-дийн дунд анх удаа кейс менежментийн үйлчилгээг нэвтрүүлсэн, “Монгол улс дахь эмэгтэй биеэ үнэлэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээний кейс менежмент” гарын авлагыг боловсруулан, үйл ажиллагаандаа хэрэглэж байна.
- 2018-2020 онд санхүүжилт 40% буурч хүний нөөц багассан тул Улаанбаатар хот, орон нутгийн дэд салбар хүлээн авагч 2 ТББ-д 19 хүн ажиллаж ажлын ачаалал 54%-иар нэмэгдсэн ч тавьсан зорилтондоо хүрсэн. 2018-2025 онд ЭБҮ-ийн дунд БЗДХ, ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг байгууллагуудын стратеги төлөвлөгөөг боловсруулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлснээр тавьсан зорилгодоо хүрэх, алсын хараагаа тодорхойлох, үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөх, манлайлах, хяналт тавих боломжоор хангагдан ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудал

- Баар, саун, массажны газрууд хаагдаж, ЭБҮ-чид байршил тодорхойгүй далд хэлбэрт шилжин үйл ажиллагаанд хамруулахад бэрхшээлтэй байна.
- Биеэ үнэлэгчид цахим орчин ашиглан үйлчлүүлэгчээ олох, харилцаа холбоо тогтоон санхүүгийн дэмжлэг авна гэсэн зарын дагуу ДУУДЛАГААР биеэ үнэлэх явдал ихсэх хандлагатай байна.
- ЭБҮ-дийн хувьд хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байна.
- ХОА, кейс менежерүүд нь шөнийн цагаар эрсдэлтэй хүнд нөхцөлд ажилладаг.
- ЭБҮ-дийг ажиллуулж буй эзэд, мадам нар үйл ажиллагаанд хамруулахаас татгалзах
- Цагдаагийн байгууллагын баривчилгаа
- ХДХВ, тэмбүүгийн шинжилгээ үйлчилгээнд хамрагдах цаг товлочихоод ирэхгүй утсаа салгаж алга болох
- Хөдөлгөөнийхний дарамт шахалт
- ЭБҮ-дийн хаяг байршил тодорхойгүй, шилжилт хөдөлгөөн ихтэй, утасны дугаараа байнга солих эсвэл буруу хэлэх
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиал медиа ашиглан буруу ташаа мэдээлэл тараах, байгууллагын нэр хүндэд халдах, олон нийт болон нийт хүн амд буруу ойлголт өгөх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх явцад хүндрэл учруулж байна.

ҮЗЗ-ийн зөвлөмж

- Өөрсдийн үйл ажиллагааны талаар олон нийтэд сурталчлах хэрэгтэй.
- Төсөл хөтөлбөрүүдийн талаар хаа хаанаа /ЭМЯ, ХЗН, ҮЗЗ болон бусад хамтрагч байгууллагууд/ нэгдсэн зөв ойлголттой байж бие биедээ зохих цаг хугацаанд нь тусламж үзүүлж хамтран ажиллах хэрэгтэй.

“Шинэ Өөдрөг Амьдрал” ТББ

Нөхцөл байдал

- Тус байгууллага нь 80-90 ХДХВ-ын халдвартай олон нийт болон тэдний ар гэрийн нийт 800-900 хүнтэй ажилладаг. Томилогдон ирсэн шинэ эмч мэргэжилтнүүдтэй харилцаж олон нийтийг ялгаварлан гадуурхалгүй, хамгаалалт үүсгэх зорилгоор хамтран ажиллаж байна. Өвчлөл УБ, Дархан, 429-р ангиудад бүртгэлтэй байдаг. Хувь хүний нууцыг хамгаалахын тулд аливаа үйл ажиллагаандаа зурган баримтжуулалт хийдэггүй. Учир нь найз нөхөд хамаатан садангаасаа айж ичдэг хаалттай хүмүүс байдаг.
- “Залуус Эрүүл Мэнд” ТББ-тай хамтран ажилладаг. ЗЭМ-ийн сургалтанд суусан хүмүүс ирэхээр илүү их мэдээлэлтэй байдаг. Түүнчлэн манай нүүр номын хуудсанд хүмүүсийн бодит түүхүүд бичигдсэн байдаг тул иргэдийн хүлээж авах байдал сайжирсан. Сургалтын гарын авлага, сурах бичиг, сурталчилгааны хуудсуудыг хэвлүүлэн авч ашиглаж байна. Олон нийтийн байгууллагаас тусламж дэмжлэг авдаг. Төслийн хүрээнд Монгол улсын 21 аймагт очиж лекц уншсан. Монгол улсад бүртгэлтэй өвчлөлтэй хүмүүсийн 9 нь одоогоор гадаадын улс орнуудад амьдарч байна.

Төслийн үр дүн:

- Зорилтот бүлэгрүүгээ чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг.
- 2018 онд шинээр бүртгэгдсэн ХДХВ-тэй 8 хүнд груп 80-90%-тай тогтоолгосон.
- ОЭТС-тэй 3 өвчтөнд эмийг уулгасан.
- 8 хүний бүрэлдэхүүнтэй уулзалтуудыг зохион байгуулдаг. Өвчлөлд өртсөн хүмүүсийг найз нөхөдтэй нь хамруулдаг.
- Хорих 429-р ангид очиж ажилладаг.
- Архи тамхины хэрэглээг бууруулж даарч хөрөхгүй байж эмээ тогтмол таслахгүй ууж байхыг хүмүүст зөвлөдөг.

Тулгамдаж буй асуудал:

- Бэлтгэгдсэн мэргэжлийн сэтгэл зүйч байхгүй.
- Нийт ард иргэдийн хандлага буруу ойлголтоос болж өвчлөлд өртсөн олон нийт маань хаагдмал болж нийгмээс өөрсдийгөө тусгаарладаг. Анхнаасаа ХДХВ-г тахал, гамшиг гэж нийгэмд тараасан болохоор нийгмийн сэтгэл зүйг өөрчлөхөд хүндрэлтэй.

САНАЛ: Сэтгэлзүйчтэй болох хэрэгцээтэй. Ингэснээр өвчлөлд өртсөн хүмүүсийг нийгмийн амьдралд оролцоод явахад нь түлхэц үзүүлэх бололцоо бүрдэнэ.

ҮЗЗ-ийн зөвлөмж

- Нийгэмд шаардлагатай байгаа зөв мэдээллийг зөв цагт нь өгч байх хэрэгтэй.

- Цаашид төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулан, ТБ-уудтай ойлголцон хамтран ажиллах хэрэгтэй.
- Түүнчлэн хичээл зааж буй багшийн мэдээлэл, зургыг тавьж тодорхой хэвшсэн цаг хугацаанд уулзалтыг зохион байгуулж байх нь оролцогчдын оролцох идэвхийг нэмэгдүүлэх давуу талтай.
- Нийгэмд зөв ойлголт хандлага өгөх үүднээс нөлөөллийн ажлыг зохих түвшинд хийж байх хэрэгтэй.
- ГС-ийн зөвлөмжийн дагуу цаашдын үйл ажиллагааныхаа тогтвортой байдлыг хангах үүднээс үйл ажиллагаануудыг эртнээс төлөвлөн санхүүжилт зогсоход авах арга хэмжээг төлөвлөх хэрэгтэй.

➤ Төв, Дундговь, Өмнөговь аймгуудын танилцуулгыг -, **ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүн** танилцууллаа. /Танилцуулгыг Хавсралт 4-өөр оруулав/

Танилцах ажлын материалыг та бүхэнд тараасан тул та бүхэнд шууд дүгнэлтийг ярих нь үр дүнтэй санагдлаа.

Дүгнэлт:

- Төв, Дундговь, Өмнөговь аймагуудад төслийн үйл ажиллагаа хангалттай хэрэгжиж байна;
- 3 аймагт ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, эм, урвалж бодисын хадгалалт, ашиглалт шаардлага хангасан;
- Дундговь аймагт 2018 онд ХӨСҮТ-ээс хийсэн дэмжлэгт хяналтаар ЭМГ болон НЭ-т 6 зөвлөмж өгсөний 66.7% (4) бүрэн биелж, механик агааржуулалтын систем ажилд орсон боловч мотор доголдолтой учир тогтмол ажиллахгүй, эмнэлгийн өргөтгөл барих асуудал хэлэлцэх шатандаа явж байна.
- ДУА-д 2018 онд ХӨСҮТ-ээс хийсэн дэмжлэгт хяналтаар ЭМГ болон НЭ-т 6 зөвлөмж өгсөний 83.3% (5) бүрэн биелж, лабораторийн урсгал дотоод зохион байгуулалттай холбоотой зөвлөмжийг байрны асуудлаас болж бүрэн шийдвэрлээгүй байна;
- Дундговь аймагт зөөврийн рентген аппарат шаардлагатай.
- Өмнөговьд 2018 онд ХӨСҮТ-ээс хийсэн дэмжлэгт хяналтаар ЭМГ болон БОЭТ-д 9 заалт бүхий зөвлөмж өгсөний 55.6% (5) бүрэн биелж, хүний нөөцийг нэмэгдүүлэх буюу сүрьеэгийн эмч бэлдэх, цэрний сорьц авах кабиныг байрлуулах ашиглах, сүрьеэгийн тасаг, амбулаторийн орчны хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар халдвар судлагч эмчийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх ажил огт хэрэгжээгүй.

ҮЗЗ-ийн зөвлөмж:

- Хурдавчилсан оношилгооны аппаратын (Жене-Эксперт) ашиглалтыг сайжруулах, лаборантын ажлын зохицуулалт хийх шаардлагаар НЭ-ийн эмч мэргэжилтнүүдэд хурдавчилсан шинжилгээний талаар тусгайлан сургалт хийх;
- Механик агааржуулалтын системийг тогтмол ажиллуулах талаар мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;
- Сүрьеэгийн тархвар судлаач эмч байхгүй тул цаашид авч ажиллуулах;
- Био Аппарат 2015 онд эвдэрч хаалга нь хаагдахгүй болж улмаар халдвар тарах эрсдэлд орсон байхад өдийг хүртэл засварлаж арга хэмжээ аваагүй байгааг нэн даруй засварлах хэрэгтэй;
- Ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн цаашдын ашиглалтанд анхаарч даатгалд хамруулах. Засвар үйлчилгээг сайжруулах;
- 20 өвчтөнд зориулсан өрөөнд 30 хүн байгаа тул өрөө байрны асуудалд анхаарах шаардлагатай;
- Халдварт, сүрьеэгийн барилга стандартын дагуу баригдаагүй;
- Аппарат, тоног төхөөрөмжийн ашиглалтын хуудсыг хэрэглэж хэвших.
- Хүний нөөцийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах.
- Шинээр баригдах байшингийн зураг гаргахдаа лабораторийн агаарын урсгалыг тооцоолж өрөө тасалгааг зөв байрлуулах зэргээр мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авах;
- Лаборант тэтгэвэрийн нас дөхөж байгаа учир сүрьеэгийн лаборант бэлтгэх;
- Сүрьеэгийн тасаг, диспансерийн механик агааржуулалтын системийн гэмтлийг шийдвэрлэх шаардлагатай;

- Сүрьеэгийн тархвар судлаач эмч байхгүй тул цаашид авч ажиллуулах;
- Аппарат, тоног төхөөрөмжийн ашиглалтын хуудсыг хэрэглэж хэвших;
- Халдвартын тасгийн 2 давхарт ашиглах өрөөний урсгалыг зөв зохион байгуулах, цэрний кабиныг суурилуулж ажиллагаанд оруулах;
- БОЭТ-ийн шинээр баригдсан байшинд эрүүл зүйн үзлэг хийх өрөө гаргаж сүрьеэгийн эмчийг хуваариар ажиллуулах;
- Сүрьеэгийн эмч нэмж сургах;

Хөдөө орон нутгийн хяналтын ажлын тайлан

- Баянхонгор, Өвөрхангай аймгуудын хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцсан ажлын тайланг **Б.Сувд, ҮЗЗ-ийн гишүүн** танилцууллаа. /Танилцуулгыг Хавсралт 5-д оруулав./
- Энэхүү уулзалтанд оролцоходоо бид бүх салбар төлөөллийн хамт явсан.

Зорилго

Төсөл хөтөлбөр саадгүй, цаг хугацаандаа, хүрэх ёстой газраа хүрч хэрэгжиж байгаа эсэхэд дэмжлэгт хяналт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

- Үйл ажиллагаатай танилцах
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт
- Амжилт, саад бэрхшээл
- Хэрэгжилтийг сайжруулах зөвлөмж

Дүгнэлт:

Сүрьеэгийн тархалтаар

Баянхонгор аймаг сүрьеэгийн өвчлөл дунд түвшний аймгийн нэг бөгөөд 2018 оны статистик тайлангаар сүрьеэгийн тохиолдлын түвшин 10 000 хүн амд 7.2 байгаа ба 2014 оноос хойш бүртгэгдсэн тохиолдлын түвшин тогтмол нэмэгдэж байна. Тус аймагт сүрьеэд өртөх өндөр эсдэлт бүлэгт ордог бичил уурхай олон тоогоор ажилладаг.

Өвөрхангай аймаг сүрьеэгийн өвчлөл бага аймагт ордог, СТСА-ны 2018 оны тайлангаар 10 000 хүн амд сүрьеэгийн тохиолдлын түвшин 3.5 байгаа нь улсын дундажаас (10 000 хүн амд 11.3) болон аймгийн дундажаас бага (10 000 хүн амд 8.4) сүүлийн 5 жилд сүрьеэгийн тохиолдлын түвшин 10 000 хүн амд 2014 онд 6.1, 2018 онд 3.5 байгаа нь буурч буйг харуулж байна.

БЗДХ-ын тархалтаар

Баянхонгор аймгийн бэлгийн замаар дамжих халдвар 2019 оны эхний улиралд 10,000 хүн амд ногдох Тэмбүүгийн тохиолдлын түвшин 5.9 (улсын дундаж 4.2), Заг хүйтэн 22.9 (улсын дундаж 4.2-оос 5 дахин өндөр) трихомониаз 17.8 (улсын дундаж 3.2-оос 5 дахин өндөр), байгаа төдийгүй өмнөх оны мөн үеэс 2-4 дахин өндөр бүртгэгдсэн байна.

Өвөрхангай аймгийн бэлгийн замаар дамжих халдвар 2018 оны байдлаар 10,000 хүн амд ногдох Тэмбүүгийн тохиолдлын түвшин 16.1 (улсын дундаж 19.4), Заг хүйтэн 9.7 (улсын дундаж 17.2) трихомониаз 7.6 (улсын дундаж 14.1), байгаа төдийгүй ХДХВ-ын 1 халдвар бүртгэгдсэн байна.

Бид ҮАБЗ-ын гишүүнтэй явж байсны хувьд зөвлөмжүүдийг өгөхдөө зөвхөн эмнэлгээр тогтохгүй тухайн аймгуудын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Аймгийн Засаг дарга болон Аймгийн Нэгдсэн Эмнэлгүүдийн удирдлагууд гэх мэт холбогдох хүмүст нь мэдээллүүдийг хүргэсэн.

Дүгнэлт

Өвөрхангай аймагт

- Зөөврийн рентген аппаратаар 2000 хүнд урдчилан сэргийлэх үзлэг хийж 2 шинэ тохиолдол илрүүлсэн. Урдчилан сэргийлэх үзлэгийг 1 техникч 900 орчим хүний зургийг 1 зэрэг авдаг нь чанарт нөлөөлөх боломжтой их ачаалалтай санагдсан.

БЗДХ-ын хувьд шинэ байранд нүүж орсон боловч бүтэц зохион байгуулалт муутай байсан. Жишээлбэл: 2 эмч дамждаг өрөөнд суудаг. 00-ын өрөө нь эмчийн өрөөнд байдаг. Тэгэхээр тэнд үйлчлүүлж байгаа иргэн хэзээ ч эмчийн өрөөнд орж 00 хэрэглэхгүй. Мөн хувцас солих өрөө байхгүй.

Эмэгтэйчүүдийн үзлэгийн ор 40 жил ашиглагдаж байгаа бөгөөд орон дээр гарах үед хөл гар урахаар хуучирсан байсан.

- Бэлгэвч, урвалжийн ханган нийлүүлэлт буурсан
- Өсгөвөрийн шинжилгээ хийдэггүй

- Термостат эвдэрсэн
- ГС-аас ханган нийлүүлсэн Суурин компьютерийг нь БОЭТ авсан. Эдгээрийг залруулах хэрэгтэй гэсэн зөвлөмжийг өгсөн байгаа.

МӨАУМХОЛБОО

- Өрхийн эмнэлэгт хөтлөгдвөл зохих бүх журнал хөтөлдөг
- Өвчтөний эмийг сар сараар нь сүрьеэгийн диспансераас хүлээн авч хянаж уулгадаг
- Цэрний сорьц цуглуулах сав, зөөвөрлөх саваар хангагдсан

Баянхонгор аймагт

Зөөврийн рентген аппаратын зөвшөөрлийг цацарагаас хараахан аваагүй тул хэрэглээгүй байсан. Гэтэл эдгээр өвчлөл тус аймагт ямар хэмжээтэй байгаа билээ.

БЗДХ-ын хувьд

- Байрандаа засвар хийсэн байсан ч агааржуулалт хангалтгүй, бохир үнэртсэн байсан
- Нэг үзлэгийн өрөө, нэг эмч тусламж үйлчилгээ үзүүлж байгаа нь чирэгдэл ихтэй
- 2019 оны эхний улирлын ХӨСҮТ-ийн Нэгдсэн лабораторын алба /НЛА/-ны БЗДХ-ын лабораторид чанарын дотоод хяналтын шинжилгээнд илгээсэн сорьцуудын онош зөрсөн, хяналтын шинжилгээнд сорьц илгээх журам алдагдсан, хуурамч эерэг, сөрөг хариу гаргах зэрэг зөрчлүүд илэрсэн.

МӨАУМХ

- Сорьцны сав байхгүй тул сорьц тэвэрлэхэд хүндрэлтэй. Тиймээс Сүрьеэгийн шинж тэмдэг илэрвэл шууд Нэгдсэн Эмнэлэгтэй илгээдэг байна. Гэхдээ очиж үзүүлсэн эсэх дээр бүртгэл байхгүй.
- Уушигны сэрвээгийн тохиолдол 1 бүртгэгдсэн ба эм уух буланд эмийг нь уулгадаг ба зарим тохиолдолд гэрээр эмийг зөөдөг.

Эдгээр аймгуудад нийтлэг ажиглагдсан зүйл бол БЗДХ-ын 1-2 эмч ажиллаж байсан нь хавьтлыг илрүүлэх ямар ч нөхцөл бололцоог бүрдүүлээгүй байсан. Хавьтал судлаач дутмаг. Лабораторийн байршил тусгаарлагдмал байсан тул тестийг зөөхөд асуудал үүсэхээр байсан. Алба зохион байгуулалтын асуудал их. Сүрьеэгийн агааржуулалтын систем хангалтгүй. Багажны ашиглалт муу байсан жишээлбэл цэрэг татлагын үеэр багажаа ашиглаж үзлэг хийх боломжоо ашиглаагүй байсан. Эдгээрээс харахад үүргийн биелэлт муу тул ҮЗЗ-ийн зүгээс албан ёсны зөвлөмжийг хүргүүлж, түүнийхээ биелэлтийг шаардаж байх хэрэгтэй санагдсан.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ТБ	Ж.Мөнхжаргал: Налайхын агааржуулалтын системийг ГС-ийн 35,000 ам.долларын санхүүжилтээр суурилуулсан байсан ба одоо шинэ байранд нүүж орохдоо хэрхэн шийдвэрлэх тал дээр анхаарал хандуулж чадсан уу? ҮЗЗ-ийн Ажлын Албанд санал өгөхөөр байна. Тус дүүрэгт хэзээ энэ санхүүжилтыг өгөөд одоо шинэ байранд нүүн орж энэ санхүүжилтыг салхинд хийсгэхээр болчихсон бэ? Гэтэл энэ жил бидний очсон Төв, Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай гээд бүх аймгуудад агааржуулалтын асуудлаа шийдвэрлэх хүсэлтэй байгаад байгаа. Энэ талаар бидэнд дараагийн хурал дээр мэдээлэл өгнө үү.
ТББ	С.Дондов: Бид яг агааржуулалтын систем гэхээсээ илүүтэйгээр цаашид орчин нөхцлийг сайжруулахаар 4 давхар барилгыг засан сайжруулж Сүрьеэгийн тасгийг тусад нь гаргахаар ажиллаж байгаа болон халаалт, бохир, цэвэр усны асуудлыг шийдвэрлэн, засварын ажлыг 2019 оны 9 сард дуусгахаар ажиллаж байгаа талаарх мэдээллийг авсан.
АШУУ ИС	Р.Оюунгэрэл: ЭБЭ хэдэн хүн, ямар насныхан байгаа талаар мэдээлэл өгнө үү. Жилд шинээр хэдэн хүн тус зан үйлд ямар шалтгааны улмаас ороод байгаа талаар хэлж өгнө үү. Түүнд чиглэсэн ямар арга хэмжээг авч байгаа талаас нь мэдээлэл өгнө үү?
ТББ	С.Дондов: Сүүлийн үед биеэ үнэлэлт далд хэлбэрт орж байгаа нь цагдаагийн байгууллагуудын баривчилгаатай холбоотой гэж ярьж байсан бөгөөд насны хувьд 15-40 хүртэлх насныхан байдаг байна. Цаашид энэ асуудлыг хумиж, багасгах талаар арга хэмжээ авч, тэдгээр хүмүүст аль болох зөв мэдээлэл өгөхөөр ажиллана гэж байсан.
ТББ	Г.Нямпүрэв: 2 жил тутам зохион байгуулдаг харуулдан тандалтын судалгаа шинжилгээгээр эрсдэлт бүлгийн хүн амын өвчлөл болон бусад нийгмийн холбогдолтой бүх асуудлуудыг гаргаж ирж байгаа бөгөөд 15-35 насныхан ЭБЭ олон нийтийн ихэнх хувийг эзэлдэг. Тэрхүү судалгаатай холбоотойгоор томоохон төлөвлөгөө боловсруулсан бөгөөд ЭБЭ олон нийтийн онцлогт тохирсон хүрч очих ажлын баг ажилладаг. Мөн төлөвлөгөөний хүрээнд эрсдэлт бүлгийн олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг.

ТБ	<p>Б.Хонгорзул: Сая ярилцсан зүйл дээрээс харахад надад дараах 2 зүйлийг тодруулмаар санагдаж байна.</p> <p>1. Хэрэгжиж буй төслийн хэрэгжилттэй танилцахаар орон нутагт баг гарган ажилладаг юм байна. Энэ ажлын удирдамжийг хэнээр, хаагуур батлуулдаг вэ? Нэгдсэн нэг зорилго, чиглэлтэй үүрэг аваад явдаг уу?</p> <p>2. Ажлын хэсэг очиж ажиллаад тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон шийдэл гаргаад зөвлөмжөө албан ёсоор хүргэдэг үү? Ер нь явсан ажлынхаа тайланг ҮЗЗ-ийн хурлаар танилцуулахаас гадна яг эдгээр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ЭМЯ болон холбогдох хүмүүстээ бичмэлээр тайлангаа өгөөд асуудлыг шийдвэрлүүлэх саналыг тавьдаг уу? Түүнчлэн өгсөн зөвлөмжийнхөө хэрэгжилтийг эргээд хэрхэн хянадаг вэ? Эдгээр тайлангуудыг сонсож байхад зөөврийн дижитал рентген аппарат шаардлагатай гэж байна. Тэгэхээр энэ асуудлыг тухайн аймаг төсөвтөө тусгах боломжтой эсэх талаар хэлэлцэн энэ төслийг үр дүнтэй болгох талаас нь ажиллавал зүйтэй санагдаж байна.</p>
ҮЗЗ-АА	<p>Б.Оюундарь: 1. ҮЗЗ өөрөө хяналтын төлөвлөгөөтэй бөгөөд Танилцах айлчлал маань хяналтын үйл ажиллагаанд ороод явдаг. Хяналтын төлөвлөгөөг жил бүр Хяналтын хорооны гишүүд хэлэлцэн батлаад ҮЗЗ-ийн хурлаар танилцуулдаг. Тэгээд тэрхүү ажлын удирдамжийг ҮЗЗ-ийн Ажлын Алба боловсруулан Хяналтын хорооны гишүүд баталдаг.</p> <p>2. Очсон газар бүртээ салбар бүрийн төлөөлөл өөрсдийн сонгогдсон салбарынхаа дагуу зөвлөгөөг амаар өгдөг. Мөн ХӨСҮТ болон боломжтой үедээ ЭМЯ-ны төлөөлөл оролцон хамт явдаг тул зохих зөвлөгөө зөвлөмжөө өгөөд явдаг. Ирсэний дараа ҮЗЗ-д танилцуулаад ЭМС-д эдгээр аймгуудад ийм асуудал гарлаа та бүхэн шийдвэрлэж өгнө үү гэж ханддаг. Тэрхүү албан бичгийг хүргүүлсэний дараа дараагийнхаа хурлаар тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээлэл авах маягаар оруулан зөвлөмжийнхөө хэрэгжилтийг хянадаг. Өнөөдрийн хурлаар гэхэд Т.Энхзаяа дарга өнгөрсөн хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулна.</p>
ТБ	<p>Ж.Мөнхжаргал: Ер нь бол ТБ-ыг төлөөлөн ҮЗЗ-д сууж байгаа хүмүүс нилээдгүй их ачаа үүрэх шаардлага гардаг. ҮЗЗ-ийн дарга ч үүнийг дэмждэг. Энд төсөв мөнгө болон ажлын ачааллын хувьд их ачаа үүрдэг. Буудлынх нь мөнгө хүрэхгүй байхад хоолныхоо мөнгийг өөрсдөө төлөөд олон юм ярихгүй ажилладаг. Ийн зүтгэж ажиллаж байгаа гишүүд та бүхэндээ баярлаж байна.</p> <p>ҮАБЗ хамт явсан Завхан, Увс, Баянхонгор, Өвөрхангай аймгуудынхаа хэмжээнд Иргэдийн төлөөлөгч, Засаг даргын тамгийн газарт үнэлгээ хийлгэж Ажлын албандаа тайлагнуулсан. Тэрхүү үнэлгээг сонсож байхад Өвөрхангай аймгийн НЭ-ийн агааржуулалтаас бусад бүх ажил хийгдсэн байна. Ингээд бодоход дээрх ажил үнэхээр сайн хэрэгжсэн байна. Тиймээс танилцах ажлын багт оролцож байгаа хүмүүстээ санхүүжилтыг нь бага зэрэг нэмэх хэрэгтэй. ҮЗЗ-г чадавхижуулах хэрэгтэй. Үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байгаа гишүүдийг үнэлэх, дараа дараагийн танилцах айлчлалд дэмжлэг үзүүлэх тал дээр анхаарагүй бол тус асуудал их хүнд байгаад байна. Мөн ЭМЯ-аас хуралд оролцоо муу байсан тул бид 2 төлөөлөл сонгосон. Гэтэл тэдгээр 2 гишүүн үзэгдээд өнгөрч байна. Тэгэхээр гишүүдээ та бүхэн тэр 2 гишүүнийг ҮЗЗ-д байлгах уу байлгахгүй юу гэдэгт дараагийн асуудлаар саналаа өгөхийг уриалж байна.</p>
ТББ	<p>Ц.Пүрэвжав: Танилцах айлчлалд ХЗН-ийн баг хамт оролцсон харагдаж байна. Тэд ямар үүрэг гүйцэтгэж байсан бэ? Тэд ажлаа хийж байсан уу? Ажиглаад явж байсан уу? Эсвэл зөвлөмж өгч байсан уу? Хөтөлбөртэй танилцаж байгаа хүмүүст тайлангаа танилцуулж байсан уу? Тэгтэл энд гарч байгаа асуудлыг ХЗН бүгдийг нь мэдэж л байсан баймаар юм.</p>
ҮЗЗ-АА	<p>Б.Оюундарь: Өнгөрсөн 3 танилцах айлчлалаар ХЗН-ээс хамт явсан бөгөөд тэдний үндсэн үүрэг нь сүрьеэгийн одоо хэрэгжиж байгаа төслийн хүрээнд ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалтай танилцаж мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилготой тусдаа удирдамжтай байсан. Явах аймгууд ижил байсан учраас нэг дээвэр дор үйл ажиллагаа явуулж буй бид дахин дахин очиж хүндрэл учруулахгүйн тулд хамт явсан. Очсоныхоо дараа бүгд хариуцсан ажлуудаа хийгээд явсан.</p>
ТББ	<p>Ц.Пүрэвжав: ХЗН-ийн ажилчдын томилолтын зардал хаанаас гардаг вэ?</p>
ҮЗЗ-АА	<p>Б.Оюундарь: ХЗН-ийн мэргэжилтнүүд өөрсдийн удирдамж, санхүүжилтээр явдаг.</p>
Хувийн хэвшил	<p>Б.Мягмар: ҮЗЗ-ийн гишүүд дангаараа танилцах айлчлалуудад оролцоходоо янз бүрийн асуудлуудад нилээд ширүүн хандаж байсан бөгөөд тухайн асуудлуудыг ҮЗЗ-ийн хурал дээр танилцуулахад ХЗН-ийн зүгээс зохих тайлбаруудыг өгдөг байсан. Тиймэрхүү тохиолдлууд цөөнгүй байсан тул хамт явах санал удаа дараа гарч байсан дээр үндэслэн ХЗН-тэй танилцах айлчлалаар хамт явах болсон. Тэгэхээр ерөнхийдөө уялдуулах байдлаар гэхдээ үйл ажиллагааны удирдамж, санхүүжилт тусдаа байдлаар явдаг. Бүсийн менежерийн зүгээс ч хоорондоо уялдаа холбоогоо сайжруулан ажиллах талаар зөвлөмжийг өгдөг.</p>

	<p>Түүнчлэн Ж.Мөнхжаргал гишүүний гаргасан саналтай санал нэг байна. Үнэхээр бид танилцах айлчлалаар явахдаа цаг заваа бардаг. Тэгэхээр урд нь энэ асуудлыг хөндөж байсан. Бүсийн менежер ирэхэд саналаа тавьдаг. Мөн 2017 онд МУ-г хариуцсан мэргэжилтэн дарга нартай уулзаж хүний хөдөлмөрийг бид маш их шулж байна. ҮЗЗ-ийн гишүүдэд урамшуулал өгөх боломж байгаа эсэх талаар ҮЗЗ-ийн гишүүд удаа дараа хүсэлт гаргаж байсанг уламжлан шийдвэрлэж өгөхийг хүссэн. Тэгэхэд өмнө хэлж л байсан хариултаа өгөхдөө “ҮЗЗ бол тухайн улс орны төслийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй сайн дураар ажиллах ёстой, ямар нэг цалин урамшуулал авахгүй” гэж байсан. Тиймээс энэ саналыг ойлгон томилолтын зардлыг аль болох нэмэгдүүлэх тал дээр ажиллах хэрэгтэй санагдаж байна. Гишүүдийн зочид буудлын зардлыг ҮЗЗ-ийн санхүүжилтээс өгөөд зам, хоногийн буюу хоолны мөнгийг нь гишүүдэд олгоод явах зохицуулалт байж болох уу? Ингэснээр ядаж гишүүдээс мөнгө гаргархгүй төсөвтөө оруулаад явах боломж байгаа биздээ?</p>
ҮЗЗ-АА	<p>Б.Оюундарь: ҮЗЗ-ийн санхүүжилт ГС-аас Сангийн яаманд шилжин орж ирдэг тул яалт ч үгүй төсвийн санхүүжилтын жишгээр томилолтын зардлыг тогтоодог.</p>
ТБ	<p>Ж.Мөнхжаргал: Дээрээс нь томилолтын зардлаасаа 10%-ийн татвар аваад байх юм.</p>
ТББ	<p>Б.Сувд: Тэр бол хууль бус асуудал шүү. Энэ асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.</p>
СОНА	<p>Индермохан Нарула: Олон улсын жишгээр урдчилгаа мөнгө авч яваад зарцуулсан мөнгөний бүхий л баримтуудаа цуглуулж авчирч өгөөд мөнгөө нөхөөд авдаг. Гол асуудал хаана байдаг гэхээр орон нутагт ажиллахдаа мөнгөө авчихаад буудалд биш хамаатан садныдаа хонох гэх мэт асуудал байна. Эдгээр аргуудад зохицуулалт хийх хэрэгтэй.</p>
ТББ	<p>Б.Сувд: Одоо улаан тарианы аян гараад байхад эмнэлгүүдэд ганцхан эмч суугаад хавьтлаа илрүүлэх ямар ч боломжгүй байгаад байна. Тиймээс хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэн хавьтал судлаачийг аймаг бүрт заавал байлгах шаардлагатай байна. Халдвар яг хаанаас гараад байгааг нь олж илрүүлэх нь туйлын чухал тул энэ аянтайгаа холбогдуулан хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэвэл яасан юм бэ?</p>
АШУУ ИС	<p>Р.Оюунгэрэл: Ерөөсөө ЭМ-ийн салбарт мэргэшсэн Хүний Нөөцийн асуудал их чухал болоод байна. Би хөдөө аймгуудаар явж байхад яг Б.Сувд гишүүний хэлж байсантай ижил БЗДХ-г эмчлэгч эмч нь кабинетдаа суугаад хавьтлын илрүүлгийн үйл ажиллагааг хийж барахгүй байж байна. Тэгэхээр:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дээрх асуудалтай холбогдуулан зөвлөмж гаргамаар байна. 2. Гаргасан зөвлөмжүүдийг хувь хүний хариуцлагатай холбоотой, тухайн орон нутгийн засаг захиргаатай холбоотой болон ЭМЯ юу хийх шаардлагатай талаарх чиглэлүүдээр гаргах шаардлагатай байна. Тэгэхээр бид явсан ажлынхаа үр дүнд суурилан төрөлжүүлсэн зөвлөмжийг гаргаж өгөх хэрэгтэй болно. Улмаар тухайн зөвлөмжүүдийнхээ дагуу ямар ажлууд хийгдсэн эсэх талаар мэдээлэл авах хэрэгтэй. Ингэхгүйгээр ЭМЯ-д бүх зөвлөмжийг өгөөд яамнаас бүх ажлыг хийх ёстой юу гэсэн асуудал үүсэхээр байна.
ЭМЯ-ҮХА	<p>Б.Цогтбаатар: Яг энэ асуудал дээр ТБ-г төлөөлж буй Ж.Мөнхжаргал гишүүн ямар байр суурьтай байна вэ? ҮЗЗ-ээс Төрийн Захиргааны Төв Байгууллагад зөвлөмж хүргүүлэх эрхтэй юу? Төгсөлтийн дараа үндсэн, төрөлжсөн сургалт гэсэн 2 хэлбэрээр явж байгаа 2 жил байсан хөтөлбөрийг бид 6 сар болгосон. Эдгээр хүмүүсийн эргэлт сайжирч байна гэсэн үг юм. Энэ хүмүүсийг хөтөлбөртөө оруулах саналыг өгвөл арай илүү бодитой гэж харж байна.</p>
АШУУ ИС	<p>Р.Оюунгэрэл: Би тархвар судлалыг АШУУИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Тэнхим зохион байгуулж байгаа эсэхийг сайн мэдэхгүй байна. ХӨСҮТ дагнан хийдэг учраас тэнд зохион байгуулах боломжтой.</p>
ТББ	<p>Б.Сувд: Энэ гурвалжны системээр явдаг юм байна билээ. Тус туршилтаар МУ 24 хүнийг сургасан байсан.</p>
ТБ	<p>Б.Хонгорзул: Бид 3 тусдаа танилцуулгаа сонсчихлоо. Энэ дотор зөвлөмжүүд нь байна. Гэхдээ яг ямар чиглэлээр зөвлөмж өгөх гээд байгаа талаараа шийдвэрийн төслөө боловсруулаад ҮЗЗ-ийн гишүүд нэгдсэн байр суурьтайгаар саналаа нэгтгэн өгөөд шийдвэрээ гаргах хэрэгтэй санагдаж байна.</p>
ОУБ	<p>А.Цэцэгмаа: Сая Б.Цогтбаатар даргын хэлсэнд саналаа хэлье гэж бодлоо. Тэгэхээр би 2017 онд ҮЗЗ-д орж ирж байхад 2 талд хуваагдаж маргалдсан талууд байсан. Одоо нэг хэсэг энэ асуудал гайгүй болж байснаа дахин энэ байдалд хүрмээргүй байна. Бид бүгд нэг л ажлын төлөө явж байна. “Та нар бидэнд зөвлөмж өгөх эрхтэй юу?” гэдэгтээ бус бид МУ-д тулгамдаж байгаа асуудлыг хамтарч шийдвэрлэх хэрэгтэй гэдэг байдлаар хандах ёстой гэж бодож байна. ГС МУ-д энэ санхүүжилтээ өгч байна. ҮХА болон асуудал хариуцаж байгаа газар нь ЭМЯ байдаг бөгөөд</p>

түүнд ҮЗЗ нь зөвлөх үүрэгтэй механизм байгаа учраас ажлаа яаж сайжруулах тал дээр зөвлөгөө өгөх чадамжтай газар гэж ойлгож байна.

Зөвлөмж:

Б.Мягмар: ЭМЯ-ны төлөөлөл болсон гишүүд хуралд тэр бүр суухгүй байгаа талаар гишүүний гаргасан саналыг үндэслэн ЭМЯ-г төлөөлөн ҮЗЗ-д орсон гишүүд та бүхэн ажлын ачаалал ихтэй бол албан ёсоор орлогч гишүүнээ томилон баталгаажуулж ҮЗЗ-д албан бичиг ирүүлэхийг хүсье. Бидний зүгээс та бүхнийхээ цаг завьг хэмнэхээр аль болох ажлын байран дээр чинь ирж хурал уулзалтуудыг зохион байгуулж асуудлуудыг хэлэлцэх чиглэлийг барьсаар ирсэн. Бид хоорондоо эдгээр асуудлуудыг ярилцаад байхаас илүүтэйгээр та бүхэнтэй санал бодлоо хуваалцах хүсэлтэй байдагаа хэлье.

Шийдвэр:

1. Дээрх танилцах айлчлалын хүрээнд зөвлөмж гаргахдаа ЭМЯ-нд өөрсдийнх нь асуудалтай холбоотой бодлогын шинжтэй асуудлуудаар, тухайн орон нутгийн ЗДТГ, шаардлагатай тохиолдолд Иргэдийн хуралд болон тухайн очсон СХА буюу очсон байгууллагатай холбоотой 3 чиглэлээр зөвлөмж боловсруулан хүргүүлэх.
2. Тайлангуудын загвар өөр байгаа тул ҮЗЗ-ийн Ажлын албанаас ҮЗЗ-ийн хурал дээр илтгэл тавихаас өмнө илтгэл тавих хүмүүсийн саналыг тусган зөвлөмжийн нэгдсэн загварт оруулан ҮЗЗ-ийн гишүүд шууд зөвлөмжөө хэлэлцдэг байдалруу дараагийн хурлаас эхлэн шилжих.
Дээрх шийдвэрүүдийг гишүүд санал нэгтгэйгээр гар өргөн баталлаа.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх Нууц санал хураалт	
Дэмжсэн>				12
Эсрэг>				
				Санал өгөхөөс түдгэлзэх

Хөтөлбөр #4

Хяналтын үйл ажиллагаа болон Хянах самбарын талаарх мэдээлэл өгөх, зөвлөмжүүдийг бэлтгэн танилцуулах; 2019-2020 оны ҮЗЗ-ийн хяналтын төлөвлөгөөг танилцуулан хэлэлцэн батлах

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

ҮЗЗ-ийн зохицуулагч Б.Оюундарь Хяналтын үйл ажиллагаа болон Хянах самбарын талаарх мэдээлэл өгөх /Хавсралт 5/, зөвлөмжүүдийг бэлтгэн танилцуулах;

2019 оны 06 сарын 14-ний өдөр ҮЗЗ-ийн Хяналтын хорооны хурал болсон. Тус хурлаар Хянах самбарын мэдээллийг танилцуулсан. Хянах самбарыг ГС-ийн дэмжлэгээр хэрэгжиж буй төслүүдийн мэдээллийг нэг хуудсанд багтаан цогц байдлаар мэдээлэл хүргэх зорилгоор боловсруулдаг. Өмнө нь ХЗН-ээс улирал бүр боловсруулан ҮЗЗ-д ирүүлдэг байсан бол сүүлийн үед ГС-ийн журам өөрчлөгдөн жилд нэг удаа үйл ажиллагааны тайлан гардаг болж үүнтэй уялдуулан хянах самбарын мэдээллийг тайлан гарсаны дараа боловсруулдаг болсон. Та бүхэнд энэ танилцуулгыг өмнө хүргэсэн тул мэдээлэлтэй танилцсан гэж найдаж байна. Тиймээс энд Хяналтын хорооны зөвлөмжийг хүргэе.

Хяналтын хорооны хурлын шийдвэрт: Хянах самбарыг хагас жил тутамд ҮЗЗ-ийн Ажлын Албанд ирүүлэн Хяналтын хорооны гишүүдээс зөвлөмжийг авч байх хэрэгтэй. Зөвлөмж өгөхийг тулд тайлбар хэсэгт шалгуур үзүүлэлтэнд хүрээгүй үйл ажиллагааны шалтгааныг дэлгэрэнгүй бичиж байх. Мөн 2019 оны эхний хагас жилийн мэдээллийг дараагийн удаагийн Хяналтын хорооны хурлаар оруулж хэлэлцүүлэх зөвлөмжийг өгч гишүүд санал нэгтгэйгээр дээрх шийдвэрийг баталсан.

Ерөнхий хяналтыг газар дээр нь очиж хийх ажлын тов

2018-2019 оны ажлын төлөвлөгөөн дээр хөдөө орон нутагт-3, УБ хотод-3 удаа хяналтын ажил хийх байсан боловч УБ –д 2 удаа зохион байгуулсан тул 2019-2020 онд хийгдээгүй нэг танилцах айлчлалыг нэмэхээр санал

оруулсаны үндсэн дээр дараах байдлаар баталсан.

		Ерөнхий хяналт хийх газар	Хугацаа	Үндэслэл
1	Улаанб аатар хот	<ul style="list-style-type: none"> • ШШГ Хорих 429-р анги. 	08-р сарын 4 дэх долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • Хоригдлуудад сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг
2		<ul style="list-style-type: none"> • Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг • Монголын улаан загалмайн нийгэмлэг 	09-р сарын 1-2 дахь долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • ТББ нь сүрьеэгийн тусламж үйлчилгээг УБ хот болон хөдөө орон нутагт үзүүлдэг; • ТББ орон гэргүйчүүдэд сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг.
3		<ul style="list-style-type: none"> • Гал голомт үндэсний хөдөлгөөн ТББ • Залуус эрүүл мэнд ТББ (ЗЭМ ТББ) 	01-р сарын 2 дахь долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • Шийдвэр гаргагч нарт нөлөөлж эрх зүйн таатай орчинг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. • ХДХВ/ДОХ-ын чиглэлээр Эрсдэлт бүлгийн хүн ам болон ЭБЭ олон нийтэд хүрч ажилладаг.
4		<ul style="list-style-type: none"> • Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлэг • Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг 	2-р сарын эхний долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • Сүрьеэгийн шинэ төслийн хүрээнд тавигдах агааржуулалтын систем байршуулах 2 дүүргийн нэг. • Эмнэлгийн шинэ байранд орно.
1	Хөдөө орон нутаг	Булган, Хөвсгөл	8-р сарын 3 дахь долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • 2018-2020 сүрьеэгийн төслөөр зөөврийн дижитал рентген аппарат нийлүүлсэн.
2		Говь-Алтай	10-р сарын 2 дахь долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • Тус аймагт ҮЗЗ сүүлийн 3 жилд танилцах ажлаар очоогүй үлдсэн бөгөөд машинаар яваад замаараа сумдаар ороод явна.
3		Баян-Өлгий, Ховд	1-р сард	<ul style="list-style-type: none"> • 2018-2020 сүрьеэгийн төслөөр Ховд аймагт зөөврийн дижитал рентген аппаратын дагалдах хэрэгслийг нийлүүлсэн.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ТБ	Б.Хонгорзул: Энэ танилцах айлчлалын төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт хүрэх үр дүн байдаггүй юм уу?
ҮЗЗ-АА	Б.Оюундарь: Одоогоор нарийвчилсан зүйлсийг оруулаагүй явах үедээ удирдамжаа гарган баталгаажуулдаг. Гишүүд үндсэн ажилтай учраас урьдчилсан байдлаар цагийн хувиараа оруулж ирээд гишүүдийнхээ цаг завьг зохицуулах боломжийг бодолцон оруулсан.
Хувийн хэвшил	Б.Мягмар: Өнгөрсөн Гүйцэтгэх хорооны хурал дээр хэлэлцсэн ҮЗЗ-ийн санхүүжилтийг хүлээн авахад тулгарч буй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар Б.Цогтбаатар дарга та бүхэнд танилцуулна. ҮЗЗ-ийн зүгээс ЭМС-ын тушаалын төслийг тус хуралдааны шийдвэрийн дагуу хүргүүлсэн. Ер нь ҮЗЗ-ийн санхүүжилтэнд ТНБД солигдох бүрт саад учирдаг. Энэ байдлыг шуурхай шийдэх үүднээс ЭМЯ-ны төлөөллүүдэд үүрэг болгосон.
ЭМЯ-УХА	Б.Цогтбаатар: Гүйцэтгэх хорооны хурлаас өгсөн үүргийн дагуу ЭМС, ЭМЯ-ны ТНБД-тай уулзаж дээрх асуудлыг ярилцсаны дагуу цаашид дахин чирэгдэлтэй байдал үүсгэхгүйн тулд зохион байгуулалт менежментийн арга хэмжээ авах хэрэгтэй гэж шийдвэрлэн ЭМС-ийн 6 сарын 21-ний өдрийн А4/296 тоот тушаал гарсан. Энэ тушаалын дагуу 1-р гарын үсгийг ЭМ-ийн Дэд Сайд, 2-р гарын үсгийг ЭМЯ-ны Ахлах нягтлан бодогч О.Уранчимэг гэсэн дарааллаар гүйлгээ хянагдах байдлаар батлагдсан. Үүний дагуу өнөөдөр өглөө холбогдох хүсэлтийг Сангийн Яаманд хүргүүлсэн. Тиймээс цаашид санхүүжилтын үе шатад ямар нэг саад гарахгүй явна гэдгийг хэлэх байна.

Шийдвэр:			
ҮЗЗ-ийн Ажлын Албанаас хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг 2019-2020 оны ҮЗЗ-ийн хяналтын төлөвлөгөөнд тусган ҮЗЗ-ийн нийт гишүүдэд хүргэж саналыг авах хэрэгтэй гэсэн саналыг нийт гишүүд санал нэгтгэйгээр баталлаа.			
Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар			
Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх Нууц санал хураалт
		Дэмжсэн>	12
		Эсрэг>	
Санал өгөхөөс түдгэлзэх			

Хөтөлбөр #5	ҮЗЗ ба түүний хороодын бүтэц, зохион байгуулалтыг танилцуулах; Хяналтын хорооны даргыг сонгох; ҮЗЗ-ийн даргын үүрэгт хугацаа дуусгавар болсонг хэлэлцэх
--------------------	--

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (гийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Б.Мягмар: Миний бие ҮЗЗ-ийн даргын үүрэгт ажлыг 2 жил хийж байна. Түүнээс өмнө үндсэн гишүүн болон Хяналтын хорооны даргын үүрэгт ажлыг хийж байсан билээ. Энд ажиллаж байх явцдаа өөрийн үндсэн ажилтай ҮЗЗ-ийн ажлыг уялдуулан холбогдох ажлуудыг амжилттай зохион байгуулж байсан билээ.

Бидний өнгөрсөн жилд баталсан дүрмээр ҮЗЗ-ийн гишүүнчлэлийг 2 жилийн хугацаатайгаар, дахин нэг удаа сонгогдох боломжтой байдлаар оруулж өгсөн. Тиймээс ҮЗЗ-ийн зарим гишүүдийн саналыг болон дүрмийн холбогдох заалтыг үндэслэн өнөөдрийн энэ хурлаар ҮЗЗ-ийн даргын асуудлыг хэлэлцэх хэрэгтэй байна. Түүнчлэн Хяналтын хорооны даргыг сонгох хэрэгтэй байгаа. Учир нь энэ хороонд одоогоор 4 гишүүн байгаа

№	Гишүүний нэр	Албан тушаал	Төлөөлөл (салбар)	Сонгогдсон хугацаа
1		Хяналтын хорооны дарга		
2	Ц.Даваасүрэн	Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нэгдсэн Холбоо	Төрийн бус байгууллага	2018-07-25
3	А.Цэцэгмаа	НҮБ-ын суурин зохицуулагчийн газар	Олон улсын байгууллага	2017-06-23
4	Г.Нямпүрэв	Залуус Эрүүл Мэнд ТББ	Эрсдэлт бүлгийн төлөөлөл	2018-01-16
5	С.Энхжин	ЭМЯ-ны мэргэжилтэн	Хяналт шинжилгээ үнэлгээний алба	2018-06-20

бөгөөд дотроос нь эсвэл нэмж нэг гишүүн сонгоод эзэнтэй болгох хэрэгтэй байна. Эдгээр бүтцүүд нь ҮЗЗ-ийн хувьд хамгийн чухал бүтэц байдаг.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ЭМЯ-УХА	<p>Б.Цогтбаатар: Хэлэлцэх асуудалтай холбоотой санал хэлье. ҮЗЗ байнга хуралддаггүй бөгөөд улиралд 1 удаа л хуралддаг. Бусад үед ҮЗЗ-ийн Гүйцэтгэх, Хяналтын хороод, Ажлын Алба, Дарга, Дэд дарга аваад явдаг. Ер нь цагаа олоогүй өөрчлөлт үйл ажиллагааг сааруулах эрсдэлтэй байдаг учраас Б.Мягмар дарга өөрийн үндэслэлээ хэлж байгаа ч хойшлуулах саналтай байна. Түүнчлэн ҮЗЗ-ийн даргын асуудал жирийн жижиг асуудал биш ГС-ийн төслийн хэрэгжилттэй холбоотой асуудал тул энэ асуудлыг ийм шуурхай байдлаар оруулж ирж хэлэлцэлгүй хойшид хэлэлцэх нь зүйтэй. Тиймээс өнөөдрийн хэлэлцэх асуудлаас гаргаад Хяналтын хорооны даргыг сонгох саналтай байна.</p>
---------	--

ТБ	Б.Хонгорзул: ҮЗЗ-ийн дүрмийг харахад даргыг сонгох талаар тодорхой зохицуулалт байхгүй байх шиг харагдлаа. Тиймээс би Б.Цогтбаатар даргын саналтай санал нэг байна.
ТБ	Ж.Мөнхжаргал: Надад албан бус байдлаар гишүүдээс мэдээлэл ирсэний дагуу энэ асуудлыг Ажлын албанд өөрт олгогдсон эрхийн дагуу хурлаар оруулахаар хүсэлт гаргасан. Нэгэнт хэлэлцүүлэх асуудлаа баталсан байна. Тэгэхээр миний хувьд танхимаас нэр дэвших хүмүүсээ хэлэлцэх саналтай байна.
ОУБ	А.Цэцэгмаа: Б.Мягмар даргадаа баярлаж байна. Миний хувьд дарга маань энэ үүрэгт ажлыг тодорхой хэмжээнд хариуцлагатай авч явж байна. Ер нь үйл ажиллагаа явуулж байгаа байдлаас нь харахад нилээд чадавхитай гэдгээ харуулж байдаг. Тиймээс би Б.Цогтбаатар даргын саналтай санал нэг байна. Цаг хугацаа нилээд өнгөрч, хурал дуусах хугацаанаас 20 минут хэтэрсэн байна. Даргын асуудлыг нухацтай хэлэлцэх шаардлагатай санагдаж байна.
Хувийн хэвшил	Б.Мягмар: ҮЗЗ-ийн гишүүдэд ойлгомжтой байлгах үүднээс хэлэхэд Дарга, Дэд дарга 2 өөр салбарын төлөөлөл байх ёстой. Тэгэхээр даргын сонгуульд ТББ-ын орон тоо намайг чөлөөлөгдсөнөөр олгогдох болно гэсэн үг юм.
ТББ	С.Дондов: ҮЗЗ-ийн дүрмийн 4.2-т “ҮЗЗ-ийн дарга, дэд даргыг ҮЗЗ-ийн гишүүдээс сонгох бөгөөд ҮЗЗ-ийн хурлаар нийт гишүүдийн нууц санал хураалтаар олонхийн саналаар сонгоно” гэжээ. Тэгэхээр нийт 21 гишүүдийн олонхи хувь байхгүй байна. Одоогоор 12 гишүүн л ирсэн байна.
ЭМЯ-УХА	Б.Цогтбаатар: Миний хувьд Б.Мягмар даргын туршлагыг сонсох хэрэгтэй. Дээрээс нь энэ хугацаандаа дараагийн ҮЗЗ-ийн даргаар ажиллах хүмүүсийн саналыг сонсоод тэднийгээ чадавхижуулах хэрэгтэй санагдаж байна. Түүнчлэн Ажлын албанаас нийт гишүүдийн тэд нь тус хугацаанд бүрэн эрхийн хугацаа нь дуусна гэсэн мэдээллийг бидэнд өгч байх хэрэгтэй. Тасралтгүй удирдлагаар хангахын тулд холбогдох албан бичгүүдийг тухайн төлөөлж буй салбарт нь өгөх ёстой. Эдгээр бэлтгэл ажлууд хангагдаагүй байна.
ОУБ	А.Цэцэгмаа: ҮЗЗ-ийн дүрмийн 4.2-т “Дарга, дэд даргын бүрэн эрхийг дуусгавар болгох тухай асуудлыг нийт гишүүдийн гуравны хоёр хувийн буюу 70 хувийн саналаар шийдвэрлэнэ” гэсэн байна. Тэгэхээр өнөөдөр ирц хүрэхгүй тул хэлэлцэх боломжгүй юм байна.
ТБ	Ж.Мөнхжаргал: Манай журам бол тодорхой байна. Тиймээс хойшлуулах саналтай байгаа хүмүүсээс саналаа хураагаад, хэрэв хойшлуулахаар болвол хугацаагаа товлоё. Бид дүрмээс гадуур зүйл огт яриагүй.
ЭМЯ-УХА	Б.Цогтбаатар: Дарга албан ёсоор хүсэлтээ өгөөгүй байгаа юм байна. Даргыг өөрчлөх болсон шалтгаан нь яг юу вэ? Өнөөдөр яагаад энэ асуудлыг ярих хэрэгтэй болсон бэ гэдэгт хариулт өгнө үү.
ҮЗЗ-АА	Б.Оюундарь: ҮЗЗ-ийн даргын гишүүнчлэлийн хугацаа дууссантай холбоотой ҮЗЗ-ийн гишүүнээс энэ асуудлыг хурлаар хэлэлцэх санал оруулсаны үндсэн дээр ҮЗЗ-ийн өнөөдрийн хурлаар оруулахаар Гүйцэтгэх хорооны хурлаар батлуулсан.
Хувийн хэвшил	Б.Мягмар: Цагаа хэмнэх үүднээс Хяналтын хорооны даргын асуудлыг одоо хэлэлцэн баталъя.
ҮЗЗ-АА	Б.Оюундарь: ҮЗЗ-ийн дүрмийн 9-р зүйл дээр хяналтын хорооны асуудлыг тусгаж өгсөн. Одоогоор 4 идэвхитэй гишүүнтэй байгаа. Өмнө нь Залуучуудын байгууллагын төлөөлөл байсан А.Нямдорж гишүүн даргалж байсан боловч үүрэгт хугацаа нь дууссан тул Хяналтын Хороо даргагүй байна. ҮЗЗ-ийн 78 дахь удаагийн хурлаар Хяналтын хорооны гишүүдийг ГС-аас тавьдаг шаардлагыг баримтлан дүрэмдээ шигтгэж өгсөн бөгөөд улмаар: Санхүүгийн талаас нь С.Энхжин, ЭМЯ-ны мэргэжилтэнг, Өвчлөлтэй олон нийтийн төлөөлөл болгож Г.Нямпүрэв, Залуус Эрүүл Мэнд ТББ, Хүний нөөцөд Ц.Даваасүрэн, Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нэгдсэн Холбоо Менежмент талаас нь А.Цэцэгмаа, НҮБ-ын суурин зохицуулагчийн газрын төлөөллийг тус тус сонгосон.
ЭМЯ-УХА	Б.Цогтбаатар: Би саналаа хэлье. Хяналтын хорооны даргаар ҮАБЗ-ийн төлөөлөл Ж.Мөнхжаргалыг сонгох саналтай байна.
ТБ	Ж.Мөнхжаргал: Энэ ажлыг би цалгардуулах магадлалтай тул арай өөр гишүүн сонгох хэрэгтэй.
Хувийн хэвшил	Б.Мягмар: Хяналтын хорооны даргын ажлыг нилээд манлайлалтай хүн хийх шаардлагатай байдаг. Тийм учраас би Б.Цогтбаатар даргын саналыг 100% дэмжиж байна. Өөр саналтай, сайн дураараа ажиллах хүн байна уу? Хэрэв байхгүй бол саналаа хураая.
Харнулт	

Шийдвэр:	
<ul style="list-style-type: none"> • ҮЗЗ-ийн дараагийн буюу 82 дахь удаагийн хурлаар ҮЗЗ-ийн даргыг сонгох асуудлыг хэлэлцэх асуудалд оруулан хэлэлцэхээр нийт гишүүдийн 10 нь гар өргөн баталлаа. Ингэхдээ дүрмийн хэрэгжилтийг хангахын тулд олонхийн буюу нийт гишүүдийн 2/3-ын ирцийг бүрдүүлэн ажиллах тал дээр Ажлын алба онцгой анхааран ажиллахыг үүрэг болгов. • ҮЗЗ-ийн гишүүд ҮЗЗ-ийн Хяналтын хорооны даргаар ТБ-ыг төлөөлж буй гишүүн Ж.Мөнхжаргалыг санал нэгтгэйгээр гар өргөн баталлаа. 	

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар			
Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх
			Нууц санал хураалт
		Дэмжсэн>	10
		Эсрэг>	
			Санал өгөхөөс түдгэлзэх

ШИЙДВЭР, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ХУГАЦАА
хөтөлбөр#3	<p>1. Дээрх танилцах айчлалын хүрээнд зөвлөмж гаргахдаа ЭМЯ-нд өөрсдийнх нь асуудалтай холбоотой бодлогын шинжтэй асуудлуудаар, тухайн орон нутгийн ЗДТГ, шаардлагатай тохиолдолд Иргэдийн хуралд болон тухайн очсон СХА буюу очсон байгууллагатай холбоотой 3 чиглэлээр зөвлөмж боловсруулан хүргүүлбэ.</p> <p>2. Тайлангуудын загвар өөр байгаа тул ҮЗЗ-ийн Ажлын албанаас ҮЗЗ-ийн хурал дээр илтгэл тавихаас өмнө илтгэл тавих хүмүүсийн саналыг тусган зөвлөмжийн нэгдсэн загварт оруулан ҮЗЗ-ийн гишүүд шууд зөвлөмжөө хэлэлцдэг байдалруу дараагийн хурлаас эхлэн шилжих.</p> <p><i>Дээрх шийдвэрүүдийг гишүүд санал нэгтгэйгээр гар өргөн баталлаа.</i></p>	ҮЗЗ-ийн Ажлын Алба	
хөтөлбөр#4	<p>ҮЗЗ-ийн Ажлын Албанаас хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг 2019-2020 оны ҮЗЗ-ийн хяналтын төлөвлөгөөнд тусган ҮЗЗ-ийн нийт гишүүдэд хүргэж саналыг авах хэрэгтэй гэсэн саналыг нийт гишүүд санал нэгтгэйгээр баталлаа.</p>	ҮЗЗ-ийн Ажлын Алба	
хөтөлбөр#5	<ul style="list-style-type: none"> • ҮЗЗ-ийн дараагийн буюу 82 дахь удаагийн хурлаар ҮЗЗ-ийн даргыг сонгох асуудлыг хэлэлцэх асуудалд оруулан хэлэлцэхээр нийт гишүүдийн 10 нь гар өргөн баталлаа. Ингэхдээ дүрмийн хэрэгжилтийг хангахын тулд олонхийн буюу нийт гишүүдийн 2/3-ын ирцийг бүрдүүлэн ажиллах тал дээр Ажлын алба онцгой анхааран ажиллахыг үүрэг болгов. • ҮЗЗ-ийн гишүүд ҮЗЗ-ийн Хяналтын хорооны даргаар ТБ-ыг төлөөлж буй гишүүн Ж.Мөнхжаргалыг санал нэгтгэйгээр гар өргөн баталлаа. 	ҮЗЗ-ийн гишүүд	

Огноо	2019 оны 11 дүгээр сар	
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр	

Хавсрах материал	Тохирох нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	X	
Хөтөлбөр	X	
Бусад /илтгэлүүд/	X	
Хавсралт 1-10	X	

БЭЛТГЭЛ АЖИЛ(Тохирох нүдийг бөглөнө үү			
	Тийм	Үгүй	
Хурлын тов, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон орлож ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах

ТОВЧИЛСОН ҮГ:	
Товчлол	Утга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЗГ	Засгийн Газар
СЯ	Сангийн Яам
ТБ	Төрийн Байгууллага
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ТНБД	Төрийн Нарийн Бичгийн Дарга
ХЗН	Хөтөлбөр Зохицуулах Нэгж
ЭМ	Эрүүл Мэнд
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл
ҮХА	Үндсэн Хүлээн Авагч
СХА	Салбар Хүлээн Авагч

БАТАЛСАН:			
Нэр>	Б.Мягмар	DATE >	2019 оны 06 сарын 28
Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	

ХЯНАСАН:			
Нэр>	Б.Оюундарь	Огноо>	2019 оны 06 сарын 28
Албан тушаал>	ҮЗЗ-ийн зохицуулагч	Гарын үсэг>	

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:			
Нэр>	Л.Номин-Эрдэнэ	Огноо>	2019 оны 06 сарын 28
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	

